

ХҮСНЭГТ 2: “САЙНШАНД САЛХИН ПАРК” ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Гүйцэтгэх арга хэмжээ	Хариуцагч	Үр дүн	Хугацаа	Төлөв (2017 оны 2-р сар)
Үндэсний зөвшөөрөл					
0.2	Төсөл хэрэгжих процессын дагуу нэмэлт зөвшөөрөл хэрэгтэй эсэхийг оруулсан төслийн зөвшөөрлийн иж бүрэн матрикс бэлтгэнэ. Тус матриксэд уг зөвшөөрлийг хэзээ авах, сунгуулах, дуусах хугацааг заана.	Санхүүжүүлэгч/ТХК	Зөвшөөрлийн иж бүрэн матрикс	Санхүүжилтийн өмнө	Гүйцэтгэсэн.
Гүйцэтгэлийн шалгуур 1: Байгаль орчин, нийгмийн эрсдэл, нөлөөлөл, түүний үнэлгээ, менежмент					
1.1	Төслийн байгаль орчин, нийгмийн менежментийн систем (БОНМС)-ийг дараах асуудлуудыг тусгасан байдлаар боловсруулж хэрэгжүүлнэ. ~ Компанийн бодлого ~ Байгууллагын чадамж, үүрэг, хариуцлага, тайлагнах процессын тайлбар ~ Эрсдэл болон нөлөөллийн тодорхойлолт ~ Сургалтын шаардлага ~ Ослын үеийн бэлэн байдал ба хариу арга хэмжээний төлөвлөгөө (ОУББХАХТ) гэх мэт үндсэн болон туслах бүх төлөвлөгөөний жагсаалт ~ Мониторинг болон хяналтын систем	Санхүүжүүлэгч, ТХК БОНМС-ийг боловсруулах Барилгын гүйцэтгэгч компани (БГК) нь БОНМС-тэй танилцаж, өөрсдийн төлөвлөгөөг боловсруулах	БОНМС	Барилгын ажил эхлэхийн өмнө ¹	Гүйцэтгээгүй.
1.2	ХО нарт зориулсан нэмэлт тайлангуудыг бэлтгэнэ. ~ Барилгын ажиллах хүчний нөлөөллийн үнэлгээ ~ Замын хөдөлгөөний нөхцөл, хөдөлгөөний нөлөөллийн үнэлгээ ~ Малчдад үзүүлэх дуу чимээний боломжит нөлөөллийн үнэлгээ ~ Сүүдэрлэлт, сэнс болон мөсний шидэгдэх эрсдэлийн үнэлгээ ~ Зам, ажилчдын байр, барилга байгууламжтай холбоотой нийгмийн нөлөөллийн үнэлгээ ~ Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээг илүү нарийвчлан тодорхойлох ~ Төслийн хаалтын үеийн байгаль орчин, нийгмийн нөлөөллийг тодорхойлох ~ Усны хэрэглээ болон боломжит олборлолтын талаар дэлгэрэнгүй мэдээллээр хангах (3.5 үзэх) ~ Экосистемийн үйлчилгээний үнэлгээ (6.1 үзэх)	Санхүүжүүлэгч, ТХК	Нэмэлт тайлангууд	Барилгын ажил эхлэхийн өмнө	Гүйцэтгэж байна.
1.3	БОНМТ-г бууруулах арга хэмжээг өргөтгөх байдлаар шинэчилнэ. Үүнд тоосжилт, дуу чимээ, замын хөдөлгөөн, биологийн олон янз байдал, хөрсний бохирдол, барилгын үеийн ажилчид, нийгмийн эрүүл мэнд, аюулгүй байдал, газар ашиглалттай холбоотой нөлөөлөл, түүний байнгын хяналт, бууруулах арга хэмжээ зэрэг нь багтана. ЦШС-ний мониторинг, менежментийн асуудал бас хамрагдана.	Санхүүжүүлэгч, ТХК, БГК	Барилгын үеийн БОНМТ Үйл ажиллагааны үеийн	Барилгын ажил эхлэхийн өмнө Үйл ажиллагаа эхлэхийн өмнө	Барилгын үеийн БОНМТ гүйцэтгэсэн. Үйл ажиллагааны үеийн БОНМТ-ний ноогийг боловсруулсан бөгөөд үйл

¹ Төслийн талбай бэлтгэх, бараа материал, техник хэрэгсэл, машин механизм зөөвөрлөж байршуулахаас өмнө

		БОНМТ бэлтгэнэ.	ажиллагаа эхлэхийн өмнө сайжруулалт хийнэ.		
1.4	ХО болон гэрээлэгч нарын төслийн талбайд байрлах байгаль орчин, эрүүл ахуй, аюулгүй байдал (БОЭААБ) болон олон нийттэй харилцах (ОНХ) мэргэжилтнүүдийг томилох	Санхүүжүүлэгч, ТХК, БГК, салхин сэнс нийлүүлэх компани	БОЭААБ болон ОНХ мэргэжилтнүүд	ХО-ын БОЭААБ, ОНХ мэргэжилтнүүд санхүүжилтийн өмнө, гэрээлэгчдийн БОЭААБ-ын мэргэжилтэн барилгын ажил эхлэхийн өмнө	Гүйцэтгэж байна.
1.5	Өмнөх болон ирээдүйд хийгдэх хэлэлцүүлэг, санал дээр тулгуурлан сонирхогч талуудын оролцоог хангах төлөвлөгөөг (СТОХТ) сайжруулах, төслийн барилгын болон үйл ажиллагааны үеийн гомдол, санал, хүсэлт барагдуулах механизм (ГСХБМ) боловсруулж хэрэгжүүлнэ.	Санхүүжүүлэгч, ТХК	СТОХТ	Барилгын ажил эхлэхийн өмнө	Гүйцэтгэсэн.
1.6	Төслийн цахим хуудсыг нээж, техникийн бус хураангуй (ТБХ) болон бусад олон нийттэй нээлттэй байх мэдээллийг байршуулна.	Санхүүжүүлэгч, ТХК	Цахим хуудас	Барилгын ажил эхлэхийн өмнө	Гүйцэтгэж байна.
1.7	СТОХТ шинэлж байгаатай холбогдуулан нөлөөлөлд өртөгч болон хөрш орших хүн ам болон малчидтай үргэлжлүүлэн харилцана.	Санхүүжүүлэгч, ТХК	Уулзалтын тэмдэглэл болон бусад нотлох баримт Шинэчилсэн СТОХТ	Барилгын ажил болон үйл ажиллагаа эхлэхийн өмнө	Гүйцэтгэж байна.
Гүйцэтгэлийн шалгуур 2: Ажиллах орчин нөхцөл					
2.1	ТХК болон БГК-ийн хүний нөөцийн бодлого, процессын (ХНБП) талаарх мэдээллийг нийцэлтэй эсэхийг хянуулахаар бэлтгэнэ.	Санхүүжүүлэгч, ТХК, БГК	ХНБП	Барилгын ажил эхлэхийн өмнө	Гүйцэтгээгүй.
2.2	Ажилчдын ГСХБМ-ыг тэдний ойлгох хэл дээр боловсруулна.	БГК	Ажилчдын ГСХБМ	Барилгын ажил эхлэх үед	Гүйцэтгээгүй.
2.3	Ажилчдын байрны менежментийн төлөвлөгөөг (АБМТ) Олон улсын санхүүгийн корпораци (ОУСК) болон Европын сэргээн босголт, хөгжлийн банкны (ЕСБХБ) зааварчилгааны дагуу боловсруулна.	БГК	АБМТ	Барилгын ажил эхлэхийн өмнө	Гүйцэтгээгүй.
2.4	Ажлын байрны эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны төлөвлөгөө (АБЭАААТ) боловсруулж хэрэгжүүлнэ.	БГК	АБЭАААТ	Барилгын ажил эхлэхийн өмнө	Гүйцэтгээгүй.
2.5	Ажиллах хүчний мониторинг байнга хийж, албадан хөдөлмөр эрхлэлтээс зайлсхийнэ.	Санхүүжүүлэгч, ТХК, БГК	Ажиллах хүчний аудит	Барилгын ажлын үед улирал тутам	Гүйцэтгээгүй.
Гүйцэтгэлийн шалгуур 3: Нөөцийн үр ашигтай зарцуулалт болон бохирдлоос урьдчилан сэргийлэх хянах					
3.1	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө (ХХМТ) боловсруулж, хэрэгжүүлэх ба түүндээ сайн туршлагуудыг тусгана. Энэ төлөвлөгөөнд хог хаягдлын урсгал, үүсэлт, тоо хэмжээ, зайлуулалт, үүсэлтээс сэргийлсэн сайн туршлага, багасалт, дахин ашиглалт, эргүүлэн ашиглалт зэрэг асуудлуудыг тусгана.	БГК	ХХМТ	Барилгын ажил эхлэхийн өмнө	Гүйцэтгээгүй.

3.2	<p>Барилгын үеийн замын хөдөлгөөний менежментийн төлөвлөгөө (ЗХМТ) боловсруулж хэрэгжүүлэх ба дараах асуудлуудыг тусгана.</p> <ul style="list-style-type: none"> ~ Замын хөдөлгөөний оргил үеийг тодорхойлох ~ Жолоочийн сургалтын шаардлага ~ Засвар үйлчилгээний шаардлага, ялангуяа дуу чимээ болон хий ялгаруулалтын хяналтад анхаарал хандуулах ~ Тодорхой ажиллагаанд зориулсан зорчих замын тодорхойлолт, үүндээ сургууль, эмнэлэг болон бусад мэдрэмтгий бүсүүдэд үзүүлэх нөлөөг багасгах зорилгоор хязгаарлалт тогтоох ~ Орон нутгийн иргэдэд садаа учруулахгүй, замын хөдөлгөөнөөс үүсэх нөлөөллийг багасгах зорилгоор үйл ажиллагааны цагийн хязгаарлалт тогтоох ~ Орон нутгийн замын хөдөлгөөнийг зохицуулах газраас зөвлөгөө авах ~ Гэнэтийн ослыг тайлагнах, хариу арга хэмжээний тодорхойлолт <p>Энэ төлөвлөгөө нь барилгын үеийн БОНМТ-ний нэг хэсэг болно.</p>	БГК	Барилгын үеийн ЗХМТ	Барилгын ажил эхлэхийн өмнө	Гүйцэтгээгүй.
3.3	<p>Дуу чимээний менежментийн төлөвлөгөө (ДЧМТ) боловсруулж хэрэгжүүлэх ба түүндээ дуу чимээний суурь үзүүлэлт, хяналтын үйл ажиллагааг оруулна. Энэ төлөвлөгөө нь барилгын үеийн БОНМТ-ний нэг хэсэг болно.</p>	БГК	ДЧМТ	Барилгын ажил эхлэхийн өмнө	Гүйцэтгээгүй.
3.4	<p>Төслийн барилгын болон хаалтын үеийн тоосжилтыг бууруулах сайн туршлагыг тодорхойлж, гэрээлэгчийн гүйцэтгэлийг хянана. Энэ бууруулах арга хэмжээ нь бохирдлыг хянах төлөвлөгөөнд (БХТ) багтана. (3.6 үзэх)</p>	БГК	Тоосжилт бууруулах сайн туршлагыг судалж, түүнийг барилгын үеийн БОНМТ-д тусгана.	Барилгын ажил эхлэхийн өмнө	Гүйцэтгээгүй.
3.5	<p>Төслийн барилгын болон үйл ажиллагааны үеийн усны хэрэглээг тооцож, гүний худгийн нөөц нь хангалттай эсэхийг баталгаажуулна. Барилгын үеийн усны хэрэглээг Сайншанд хотын хаанаас хангахыг нарийвчлан заах, усны ашиглах боломжит нөөцийг баталгаажуулна. Түүнчлэн төслийн барилгын болон үйл ажиллагааны явцад төслийн талбайн ойролцоо гүний худаг гаргах шаардлагатай эсэхийг тодорхойлж, ус ашиглалт нь малчид болон бусад хэрэглэгчдэд нөлөөлөл үзүүлэх эсэхийг үнэлнэ.</p>	Санхүүжүүлэгч, ТХК, БГК	Нэмэлт тайлангийн холбогдох бүлэг	Барилгын ажил эхлэхийн өмнө	Гүйцэтгэж байна. Усны хэрэглээний төлөвлөгөөг хийсэн ба тайланг шинэчилнэ.
3.6	<p>Тоосжилт бууруулах, асгаралт, материал тээвэрлэлт, тэдгээрийн хяналт зэргийг багтаасан БХТ боловсруулж хэрэгжүүлнэ.</p>	БГК	БХТ	Барилгын ажил эхлэхийн өмнө	Гүйцэтгээгүй.
Гүйцэтгэлийн шалгуур 4: Нийтийн эрүүл ахуй, аюулгүй байдал					
4.1	<p>Нийтийн эрүүл ахуй, аюулгүй байдлын (НЭААБ) асуудлууд эрүүл мэнд, аюулгүй байдал, байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд (ЭМАББОМТ) хэрхэн туссан талаарх мэдээллээр хангана. Үүнд орон сууц, ус, ариун цэвэр, тээвэр, мэдээлэл, харилцаа холбоо, халдварт өвчний асуудлуудыг тусгана.</p>	Санхүүжүүлэгч, ТХК, БГК	ЭМАББОМТ	Барилгын ажил эхлэхийн өмнө	Гүйцэтгээгүй.
4.2	<p>Төслийн талбайн хамгаалалтын асуудлыг шийдвэрлэж, түүндээ бүртгэлтэй сургагдсан хамгаалалтын ажилтан эсвэл компанийг ашиглана.</p>	Санхүүжүүлэгч, БГК	Төслийн талбайн хамгаалалтын протокол	Төслийн талбайг бэлтгэхийн өмнө	Гүйцэтгээгүй.
4.3	<p>ОУБХАХТ боловсруулж хэрэгжүүлэх ба түүнийгээ төслийн ойролцоох ослын үед</p>	Санхүүжүүлэгч,	ОУБХАХТ	Барилгын ажил	Гүйцэтгээгүй.

	үйлчилгээ үзүүлдэг газрууд болон ард иргэдэд тараана.	ТХК	эхлэхийн өмнө	
Гүйцэтгэлийн шалгуур 5: Газар ашиглалт ба нүүлгэн шилжүүлэлт				
5.1	Нөлөөлөлд өртөгч малчид болон орон нутгийн холбогдох газруудтай хэлэлцсэний үндсэн дээр амьжиргааг дээшлүүлэх төлөвлөгөөг (АДТ), нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөө (НШТ) боловсруулж хэрэгжүүлнэ. Сөрөг нөлөөллийг бууруулах нэмэлт арга хэмжээг тохиролцож, ОУСК-ийн гүйцэтгэлийн шалгуур 5-д нийцэж буй эсэхийг хянуулна (Байгаль орчин, нийгмийн нийцлийн аудитын тайлангийн хавсралт В-д дурдсан АХТ-ний зөвлөмжийг үзнэ үү).	Санхүүжүүлэгч, ТХК	АДТ	Санхүүжилтийн өмнө Гүйцэтгэсэн.
5.2	Барилгын ажлын дараа бэлчээрийн талбайг үргэлжлүүлэн ашиглах боломжтой эсэхийг бэлчээрийн талбайд аудит хийж тодорхойлно. Хэрвээ уг талбай нь цаашид бэлчээрийн зориулалтаар ашиглах боломжгүй гэсэн дүгнэлт гарсан тохиолдолд амьжиргааг дээшлүүлэх нэмэлт арга хэмжээ авна.	Санхүүжүүлэгч, ТХК	Бэлчээрийн чанарын аудитын тайлан Шинэчилсэн АДТ (шаардлагатай тохиолдолд)	Барилгын ажил дууссанаас 1 сарын дараа БЧА, 2 сарын дараа АДТ шинэчилнэ. Гүйцэтгээгүй.
5.3	ГСХБМ-ыг нөлөөлөлд өртөгч малчдад түгээнэ. Нүүлгэн шилжүүлэлтийн ГСХБМ-ыг тусад нь боловсруулах шаардлагагүй.	Санхүүжүүлэгч, ТХК	Түгээлтийн баталгаа, уулзалтын тэмдэглэл	Барилгын ажил эхлэхийн өмнө Нээлттэй.
Гүйцэтгэлийн шалгуур 6: Биологийн олон янз байдлын хамгаалал ба амьд байгалийн нөөцийн тогтвортой менежмент				
6.1	Экосистемийн үйлчилгээний үнэлгээ хийнэ. Ялангуяа усны хэрэглээ болон бэлчээрийн газрын асуудлыг онцгойлон тусгана.	Санхүүжүүлэгч, ТХК, байгаль орчны зөвлөх	Нэмэлт тайлангийн холбогдох бүлэг	Барилгын ажил эхлэхийн өмнө Гүйцэтгэж байна.
6.2	Биологийн олон янз байдлын үйл ажиллагааны төлөвлөгөө (БОЯБУАТ) боловсруулж хэрэгжүүлнэ. Үүндээ БОЯБ-ын өмнөх судалгааны (БОННУ 2009, 2015, БОНЕУ 2014, Монтис 2015) үр дүнгүүдийг нэгтгэхийн зэрэгцээ дараах нэмэлт мэдээллүүдийг оруулна. ~ Төслийн талбай доторх бүх төрлийн амьдрах орчны зураглал хийх, ингэхдээ ОУСК-ын гүйцэтгэлийн шалгуур 6 дагуу өөрчлөгдсөн болон байгалийн амьдрах орчин, мөн ЕХОБ-ны стандарт 3 дагуу байгалийн, хагас байгалийн, хотын амьдрах орчин гэж ангилна. ~ Судлаач, байршил, хугацаа, хэмжилт гэх мэт хээрийн судалгааны арга зүй, баримт бичгийн судалга, орон нутгийн биологичтой хэлэлцүүлэг хийх ~ БОЯБ-ын төлөв байдлын тайланд хяналт хийж, аливаа хийдэл, нэмэлт судалгаа хэрэгтэй эсэхийг тодорхойлох ~ Төслийн үйл ажиллагаанаас амьдрах орчин болон хамгаалагдсан төрөл зүйлд аливаа нөлөөлөл буй эсэхийг тогтоох, ингэхдээ нөлөөллийн иж бүрэн жагсаалт гаргах (шувуу болон сарьсан багваахай илүү эрсдэлтэй тул онцгой анхаарах) ~ Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг нарийвчлан тогтоох, ингэхдээ байгалийн амьдрах орчныг онцгойлон авч үзнэ. Бууруулах арга хэмжээний төлөвлөгөөг БОЯБУАТ-д тусгах ~ Барилгын ажлын дараа нөлөөлөлд өртсөн төрөл зүйл, амьдрах орчны мониторингийн төлөвлөгөө боловсруулах ~ Харь зүйлийн тархалтаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг төлөвлөх, ингэхдээ харь	Санхүүжүүлэгч, ТХК, байгаль орчны зөвлөх	БОЯБУАТ ХЗМТ (шаардлагатай тохиолдолд)	Санхүүжилтийн өмнө БОЯБУАТ-ний эхний хувилбар хийгдэнэ. Барилгын ажил эхлэхийн өмнө нэмэлт судалгааг гүйцэтгэж, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг тодорхойлно.

Environmental and Social Action Plan

14.02.2017



	зүйлийн менежментийн төлөвлөгөөг (ХЗМТ) шаардлагатай тохиолдолд тусад нь боловсруулах				
6.3	БОЯБ-ын төлөв байдлын үнэлгээг хийх явцад тодорхойлогдсон Идлэг шонхор (Saker falcon) болон бусад төрөл зүйлийн чухал амьдрах орчны үнэлгээг хийнэ. (6.2 үзэх)	Санхүүжүүлэгч, ТХК, байгаль орчны зөвлөх	БОЯБУАТ-ний холбогдох бүлэг	Санхүүжилтийн өмнө БОЯБУАТ-ний эхний хувилбар хийгдэнэ.	Гүйцэтгэсэн.
Гүйцэтгэлийн шалгуур 8: Соёлын өв					
8.1	Соёлын өв, эртний олдворыг олох үеийн үйл ажиллагааны процессыг боловсруулж, бүх ажилчдыг сургалтад хамруулах	БГК	Олдворын үеийн процесс	Барилгын ажил эхлэхийн өмнө	Гүйцэтгээгүй.